



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 04 өдөр,

Дугаар А/3

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолын 02, 03 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт худалдан авах ажиллагааг зохион байгуулах захиалагчийн эрхийг шилжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны
01 дугаар сарын 07 өдрийн А/З
дугаар захирамжийн хавсралт

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугаца а	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих дүн
1	Чингис хаалганы орчны тохижилт	2018	20 000,0	20 000,0 /ОНТөсөв/
2	Хэрлэн сумын орон сууцнуудын дээвэр, орцны засвар	2018	212 000,0	212 000,0 /ОНТөсөв/
3	"Мянган нуурын хотгор" дэд хөтөлбөр	2018	20 000,0	20 000,0 /ОНЗСан/
4	"Өндөрхаан хот тохижилт" ОНТҮГ-т хогны машин	2018	109 500,0	109 500,0 /ОНХСан/

СЮЛ... (мян.төгрөг)